



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 5/47

Улаанбаатар хот

Б.Хэрлэнчимэгийг  
шилжүүлэн ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын 2.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 1/7553 тоот албан бичиг, Б.Хэрлэнчимэгийн 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдөр гаргасан өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн мэргэжилтэн /шинжээч/ Бужгар овогтой Хэрлэнчимэгийг үүрэгт ажлаас чөлөөлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрх мэдэлд шилжүүлсүгэй.

2. Б.Хэрлэнчимэгийн ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулж зохих журмын дагуу тэмдэглэл үйлдэн 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн дотор хүлээн авахыг Зохиогчийн эрхийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР



000695